

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.09 № 30
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАНДИНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох тухай А/68 дугаар тушаал, БОАЖС-ын 2023 оны А/642 дугаар тушаал “Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай”-ыг үндэслэн 11,313.7 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Экспедиц буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх, үүл буудах ажиллагааг явуулахад хариуцсан инженерээс бусад оролцсон 6 инженерт үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож экспедицэд ажилласан хугацаанд ажил хавсран ажилласны нэмэгдлийг шийдвэргүйгээр олгосон байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

6325050028

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,329,941.64	1,449,275.44
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,225,254.33	1,174,781.84
	Нийт хөрөнгийн дүн	2,555,195.97	2,624,057.28
	Нийт өр төлбөрийн дүн	0	4,340.60
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,555,195.97	2,619,716.68
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,555,195.97	2,624,057.28
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,964,299	3,266,105
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,162,862	3,200,558
	Үйл ажиллагааны үр дүн	801,437.23	65,547.40
	Үйл ажиллагааны бус үр дүн	117.44	1,026.69
	Үйл ажиллагааны нийт үр дүн	801,319.80	64,520.72
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,751,990	2,555,196
	Тайлант оны үр дүн	0	64,520.72
	Эцсийн үлдэгдэл	2,555,196	2,619,717
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,319,742	3,103,970
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,103,954	3,093,970
	Үйл ажиллагааны ЦМГ	215,788	10,000
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-215,788	-10,000
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,094,294	3,080,320
	Урсгал зардал	3,094,294	3,080,320
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0	0
	Улсын төсвөөс санхүүжих	0	3,080,132
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино.

Ус цаг уур, байгаль орчны байдлын бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр аймгийн төр засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хангах Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний сүлжээг арга зүй, мэргэжлийн удирдлагаар хангах, Ус цаг уур, байгаль орчны зүй тогтол горимыг тогтоох, судалгаа дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт гаргах, Булган аймгийн уур амьсгалын төлөв байдлыг үнэлэх, түүний хувьсал өөрчлөлтийн байгаль

орчинд нөлөөлөх байдлыг судлах, үнэлгээ өгөх, Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах зорилттой байна.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэн

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоох тухай А/68 дугаар тушаал, БОАЖС-ын 2023 оны А/642 дугаар тушаал “Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай”-ыг үндэслэн 11,313.7 мянган төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Экспедиц буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх, үүл буудах ажиллагааг явуулахад хариуцсан инженерээс бусад оролцсон 6 инженерт үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож экспедицэд ажилласан хугацаанд ажил хавсран ажилласны нэмэгдлийг шийдвэргүйгээр олгосон байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн аудитыг хослуулан шалгасан боловч нийцлийн аудиттай холбоотой алдаа зөрчил үүсээгүй байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг зохистой удирдаж зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийхгүй байх.

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,168.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,908.1 мянган төгрөгийн 3 алдаа , 5,260.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч төлбөрийн акт, зөвлөмж өглөө.

1. Тайлант оны завсрын аудитаар үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, малын А данс, авто машины засвар үйлчилгээтэй холбоотой 9,168.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 5,260.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29,658.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Экспедиц буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх үүл буудах ажиллагааг явуулахад хариуцсан инженерээс бусад оролцсон 6 инженерт үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож экспедицэд ажилласан хугацаанд ажил хавсран ажилласны нэмэгдэл бодож олгосон нь дээд газрын шийдвэргүйгээр олгосон байна.

8.2 Албан шаардлага бичигдээгүй

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгтэй холбоотой

Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар шуудан холбоо 615.4, тээвэр шатахуун 685.0, байгууллагад төлөх 3,040.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
УЦУОШТ-ийн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг олгодог боловч хурлын тэмдэглэлийг зөвлөлийн гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй олгосон.	1	0	1	0			1	0				
УЦУОШТ-ийн дансанд бүртгэлтэй 26 тооны 1,150.0 мянган төгрөгийн малыг санхүүгийн тайланд бүртгэсэн боловч жилийн эцсийн мал тооллогын А дансгүйгээр бүртгэсэн.	1	1,150.0	1	1,150.0			1	1,150.0				
УЦУОШТ-ын хэрэглээнд ашиглагдаг TOYOTA HILUX загварын автомашинд моторын гинж сунсан тул "Шайнинг проспект" ХХК-тай гэрээ байгуулж 2025 оны 05 дугаар сарын 05-аас 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүлээлгэж өгөхөөр	1	2,758.1	1	2,758.1			1	2,758.1				

гэрээ байгуулж шаардлагатай сэлбэгийг авсан боловч гэрээнд заасан хугацаанд ажил хүлээлцсэн акт үйлдээгүй.													
Дүн	3	3,908.1	3	3,908.1				3	3,908.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Экспедиц буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх үүл буудах ажиллагааг явуулахад хариуцсан инженерээс бусад оролцсон 6 инженерт үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож экспедицэд ажилласан хугацаанд ажил хавсран ажилласны нэмэгдэл бодож олгосон.	1	919.9	1	919.9									
Жилийн эцсийн байдлаар шуудан холбоо 615.4, тээвэр шатахуун 685.0, байгууллагад төлөх 3,040.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн.	1	4,340.6					1	4,340.6					
Дүн	2	5,260.5	1	919.9			1	4,340.6					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						